

01



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

᠑᠒᠔1 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 131

Номгон

**Хог хаягдлын менежментийг сайжруулах
аймгийн хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын "е", Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хог хаягдлын менежментийг сайжруулах аймагийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахыг аймагийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймагийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

0121274



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

“Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр” бодлогын баримт бичигт 2025 он хүртэл аймгийн хог хаягдлын хэмжээг бууруулах, менежментийг сайжруулах цогц арга хэмжээнүүдийн чиглэлийг тодорхойлсон болно. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр аймгийн нийт хог хаягдлын хэмжээ 30-аас доошгүй хувиар буурч, хог хаягдлын менежментийн тогтолцоог бүрдүүлэн улмаар дараагийн үе шатанд буюу 2030 гэхэд “Тойрог эдийн засаг” буюу хаягдлыг тэглэх суурийг бий болгоно.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хөтөлбөрийн зорилго: Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр бол ногоон эдийн засгийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй чухал ажлуудын нэг болох хог хаягдлаа дахин боловсруулж эргүүлж ашиглах ажлуудыг эрчимжүүлэх инновацийн удирдлагаар хангахыг гол зорилгоо болгосон. Хөтөлбөрийн нэг гол үзэл санаа нь хог хаягдал бол бүрэн ашиглагдах нөөц болохыг аймгийн хөгжлийн бодлого болохыг хүлээн зөвшөөрч, “Тойрог эдийн засаг” буюу хаягдлыг тэглэх зарчим юм.

1.2 Хөтөлбөрийг боловсруулсан аргачлал. Хог хаягдлын менежментийн энэхүү дэд хөтөлбөрийг Олон Улсын Хатуу Хог Хаягдлын Нийгэмлэгээс гаргасан (ISWA) цуврал зөвлөмжүүд болон Монгол улсын хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд (2017-2030) үндэслэн боловсруулав. Энэ хөтөлбөрийн гол үзэл баримтлал болох Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийн шатлалын бүдүүвчийг 2-р зурагт үзүүлэв. Энэ нь хог хаягдлыг бууруулах үндэс болох бөгөөд шатлалууд нь тухайн стратегийн чухал байдлыг илэрхийлсэн болно.

Reduce-хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах
Reuse-хог хаягдлыг дахин ашиглах
Recycle-шинэ бүтээгдэхүүн болгох
Recover-ангиалан ялгасан хаягдлаас эрчим хүч бий болгох
Landfill-хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюулгүй үлдэгдэл хаягдал

Энэ хөтөлбөрийн гол үзэл баримтлал болох Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийн шатлалын бүдүүвчийг 2-р зурагт үзүүлэв. Энэ нь хог хаягдлыг бууруулах үндэс болох бөгөөд шатлалууд нь тухайн стратегийн чухал байдлыг илэрхийлсэн болно.

Хөтөлбөрийг боловсруулах үйл явц.

Нөхцөл байдлын судалгаа:

- аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд
- хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгаа
- хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлийн үнэлгээ
- хог хаягдлын менежментийн тэргүүн туршлага

Асуудлууд ба шийдлүүд тодорхойлох

- хог хаягдлын үүсэх хэмжээ, асуудлууд, шийдлийн таамаглал хувилбарууд
- эрх зүйн үндэслэлийг боловсронгуй болгох
- оролцогч талуудын үүрэг, хариуцлага
- хог хаягдлын менежмент ба технологийн шинэчлэл
- хог хаягдлын менежментийн бүтэц зохион байгуулалт, санхүүжилт
- бүх нийтийн боловсрол, сургалт, сурталчилгаа

Санал асуулга, урьдчилсан хэлэлцүүлэг

- сонирхогч талуудын уулзалт
- олон нийтийн дунд явуулсан санал асуулгын судалгаа
- аймаг, сумын удирдлагын дунд явуулсан санал асуулга

Эцсийн баримт бичиг

- "Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр" бодлогын баримт бичиг
- Баянхонгор аймгийн хог хаягдлын мастер төлөвлөгөө

Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор тулгамдаж буй асуудал, түүнийг шийдэх боломжит арга замуудыг тодорхойлохдоо ажиглалтын, оролцооны, асуулгын, ярилцлагын зэрэг аргуудыг өргөн ашигласан.

ХОЁР. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1 Салбарын талаарх ерөнхий мэдээлэл: Хатуу хог хаягдал

Монгол Улсын хэмжээнд төвлөрсөн хогийн цэгт хүргэж, дарж булж буй нийт хог хаягдлын хэмжээ: Монгол Улсын хүн амын өсөлт хурдацтай явагдаж, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ жилээс жилд өргөжин тэлж, хүн амын орлого, хэрэглээний нэр төрөл нэмэгдэхийн хэрээр хог хаягдлын үүсэх хэмжээ үүнийг дагаад өсөн нэмэгдэж байна. Хэдийгээр Монгол Улсын хэмжээнд нийт үүсч буй хог хаягдлын хэмжээний талаар нарийвчилсан тоон мэдээлэл байхгүй ч улсын хэмжээнд төвлөрсөн хогийн цэгт хүргэж, дарж булсан нийт хог хаягдлын хэмжээ 2018 онд 3,353,548.73 тоннд хүрсэн буюу 2008 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдсэн байна.

2018 оны байдлаар төвлөрсөн хогийн цэгт хүргэж, дарж, булж буй нийт хогийн 1,393,753 тн буюу 41.6% нь Улаанбаатар хотод үүссэн бол үлдсэн 1,959,795 тн буюу 58.40% хог хаягдал нь хөдөө орон нутагт бүртгэгджээ.

Улсын хэмжээнд хог хаягдал нь жил бүр дунджаар 281,706 тн оор нэмэгдэж байгаа ба хог хаягдлын дийлэнх хувийг (2.8 сая тонн) хөрсөнд дарж булдаг бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан, байгаль орчинд ээлтэй байдлаар дарж булах үйл ажиллагааг цогц байдлаар явуулдаг ландфилл цэгүүдийг улс орон даяар хараахан байгуулаагүй байна.

Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 390-н төвлөрсөн хогийн цэг 7685.93 га талбайг хамран үйл ажиллагаа явуулдаг гэсэн бүртгэл байна.

2017 онд Монгол Улсын Их хурлаар шинэчлэн батлагдсан хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлын төвлөрсөн цэгийг 3 зэрэглэлд хувааж байгаа бөгөөд 1-р зэрэглэлийн хогийн цэгийн ландфиллын байгууламж нь шүүрлээс хамгаалах доторлогоотой, ландфиллын батлагдсан зурагтай, шүүрэл цуглуулж, цэвэршүүлэх системтэй, хучилтын хөрс нөөцлөх талбайтай, хий зайлуулах, хуримтлуулах системтэй, ландфиллын үйл ажиллагаанд зориулсан машин механизмтай, хог тээврийн автомашин ариутгаж, цэвэрлэдэг байхаар заасан бол 2-р зэрэглэлийн хогийн төвлөрсөн цэг нь шүүрэл хуримтлуулах системтэй боловч цэвэршүүлэх системгүй, хий зайлуулах хоолойтой боловч хуримтлуулах системгүй, нэвчилтээс сэргийлэх доторлогоогүй зэргээрээ 1-р зэрэглэлийн хогийн цэгээс ялгаатай. Харин 3-р зэрэглэлийн төвлөрсөн хогийн цэг нь 1, 2-р зэрэглэлтэй адил ландфиллын байгууламжгүй ба хог хаягдал салхиар тарж хийсэхээс хамгаалсан хашаатай, машин техниктэй байх юм.

Нийт хог хаягдалд дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь хэмжээг харуулсан нэгдсэн тоо баримт хараахан байхгүй бөгөөд төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн өгдөг тоон мэдээллүүд эх үүсвэрээс хамааран өөр өөр байдаг. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан (2017-2018) -гийн дагуу Монгол улсын нийт хог хаягдалд дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувийг 10 хүрэхгүй хувь байна гэсэн байдаг. Байгаль орчны мэдээллийн сан www.eic.mn -ээс 2018 онд улсын хэмжээнд дахин боловсруулсан нийт хог хаягдлыг, цуглуулж, тээвэрлэж дарж булсан хог хаягдалд харьцуулбал 7.31 %-ийг эзэлж байна. Улаанбаатар хотын хувьд нийт үүсч буй хог хаягдлын 17.5 %-ийг дахин боловсруулж байгаа бол орон нутгийн хувьд дөнгөж 0.06 % тай байна. Харин Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооноос өгч буй зарим мэдээ, мэдээллийн дагуу жилд нийт 300 мян.тонн хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулахаас гадна БНХАУ руу экспортолж байна. Энэ нь нийт үүсч буй хог хаягдлын 8.9 хувь юм.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн зүгээс Байгаль орчин, аялал жуулчлалын яам, УБ хотын Захирагчийн ажлын алба, Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй Хог хаягдал ба уур амьсгалын өөрчлөлт төслийн хүрээнд 2018 онд Улаанбаатар хотноо хог хаягдлын бүтцийн судалгааг хийсэн бөгөөд уг судалгааны үр дүнгээс харвал:

Хүснэгт 1: Нэг хүнд ногдох хог хаягдлын хэмжээ, 2018 он

Ангилал	Хэм.нэгж	Хог үүсгэх нэгж хэмжээ
Орон сууц (зун)	гр/хүн/өдөр	419
Орон сууц (өвөл)	гр/хүн/өдөр	427
Гэр хороолол (зун)	гр/хүн/өдөр	609
Гэр хороолол (өвөл)	гр/хүн/өдөр	1,530

2.2 Салбарын талаарх ерөнхий мэдээлэл: Шингэн хог хаягдал

Хөдөө орон нутагт буюу аймгийн төвүүд, сумдад нөхцөл байдал Улаанбаатар хоттой харьцуулбал илүү хүндрэлтэй байна. Аймгийн төвийнхний зөвхөн 27% нь цэвэрлэх байгууламжид холбогдсон бол дийлэнх хувь нь буюу 61% нь нүхэн жорлонтой байна. Сумдууд дээрх хүн амын 60% нь ямар нэгэн зориулалтын 00 ашигладаггүй бөгөөд зөвхөн 37% нь нүхэн жорлонтой ажээ. Ариун цэврийн байгууламжуудыг ерөнхийд нь ариун цэврийн шаардлага хангасан болон шаардлага хангаагүй гэж 2 ангилдаг. Одоогоор Монгол Улсын хэмжээнд ариун цэврийн байгууламжийн төрөл тус бүрээр нарийвчилсан дата мэдээлэл байхгүй байна.

Нүхэн жорлон: Хүнээс гадагшлах шээсний 91-96% нь ус, үлдсэн хэсгийг эрдэс давс, органик нэгдлүүд эзэлдэг. Харин өтгөний 75%-г ус, үлдсэн 25%-г уураг, бактери, задраагүй өөх тос, нүүрс ус гэсэн хэсгүүд бүрдүүлдэг. Нүхэн жорлонд хуримтлагдсан ялгадсын шингэн хэсэг нь ууршиж агаарт шивтрийн хий дэгдээхээс гадна хөрсөнд шингэдэг бол өтгөн хэсэг нь нүхэн жорлонгийн ёроолд тунан бактерийн тусламжтайгаар задралд ордог. Нүхэн жорлонгийн өтгөн ялгадасны дээд гадаргуу нь агаартай орчин тул тэнд хүчилтөрөгчөөр амьсгалагч бактери аэроб задралыг явуулдаг. Харин хуримтлагдсан өтгөний дотор агааргүй байдаг тулд тэнд хүчилтөрөгчгүй орчинд амьсгалах чадвартай бактери анаэроб задралыг явуулдаг. Аэроб задралын үр дүнд ус, нүүрсхүчлийн (CO₂) хий, харин анаэроб задралын дараа ус, органик хүчил, метаны (CH₄) хий бий болдог.

Монгол Улсад энгийн нүхэн жорлонгийн MNS 5924:2015 стандартыг 2016 онд шинэчлэн баталсан боловч одоог хүртэл дийлэнх айл өрх стандартын жорлон ашиглахгүй байна.

2.3 Хог хаягдлын салбараас ялгарах хүлэмжийн хий

Хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хийг тооцохдоо айл өрх болон үйлдвэрээс гарах хатуу, шингэн хог хаягдлыг аль алиныг нь харгалзан үзэж тооцооллыг хийдэг. Хүн амын өсөлт, хурдацтай явагдах хотжилт болон үйлдвэржилт зэрэг нь хог хаягдлын хэмжээ өсөхөд нөлөөлдөг бөгөөд үүнийг дагаад хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хийн хэмжээ мөн өсөх хандлагатай байдаг.

Өмнөх жилүүдэд НҮБ-ийн Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлж байсан тайлан, мэдээллүүдэд хог хаягдлаас

ялгарах хүлэмжийн хийн тооцооллыг хэрхэн хийсэн талаарх мэдээллийг доор товч орууллаа.

Хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хийг тооцоходоо хатуу хог хаягдлыг дарж булах үйл ажиллагаа явуулдаг хогийн цэгүүдээс ялгарах метан хий, бохир усыг цэвэрлэх байгууламжаас гарах метан хий мөн хүний ялгадаснаас гарах азотын исэл зэргийг харгалзан үздэг.

Тээвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч гэх мэт томоохон салбаруудтай харьцуулахад хог хаягдлаас гарч буй хүлэмжийн хийн ялгарал харьцангуй бага. 2014 оны байдлаар хог хаягдлаас ялгарах нийт хүлэмжийн хийн хэмжээ 159.91, ГгСО₂-эк байсан бөгөөд энэ нь Монгол улсын нийт ялгарлын 0.46% байна

Хог хаягдлаас ялгарч байгаа хүлэмжийн хийн хэмжээ жилээс жилд маш хурдтайгаар өсөн нэмэгдэж ирсэн бөгөөд энэ нь Монгол улсад эрчимтэй явагдсан хотжилт, хүн амын өсөлттэй шууд холбоотой юм. 1990 онтой харьцуулахад (55.62 ГгСО₂-эк) 2014 онд хог хаягдлаас ялгарч буй нийт хүлэмжийн хийн хэмжээ 104.29 ГгСО₂-эк буюу 187.49%-иар нэмэгдсэн байна. Мөн 2014 оны үзүүлэлтийг өмнөх жил буюу 2013 онтой харьцуулахад 7.93%-иар өсөн нэмэгдсэн байна.

2014 оны байдлаар хатуу хог хаягдлыг дарж булах үйл ажиллагаа явагддаг хогийн цэгийн метан хийний ялгарал 1990 оныхтой харьцуулахад 463.35%-иар, үйлдвэрийн хаягдал уснаас ялгарах метан хийний хэмжээ 89.48%-иар тус тус нэмэгдсэн байна. Ахуйн хаягдал уснаас ялгарах метан хий болон азотын исэл 87.56 болон 69.71 хувиар тус бүр нэмэгдсэн ажиглагдаж байна. Мөн 2014 оны байдлаар хогийн цэгээс ялгарах хүлэмжийн хий нийт хог хаягдлаас ялгарч буй хүлэмжийн хийн 54.02%-ийг эзэлж байгаа бол ахуйн бохир уснаас ялгарах хүлэмжийн хий 35.96%, үйлдвэрийн бохир уснаас ялгарах хүлэмжийн хий 10.02%-ийг тус тус эзэлж байна.

Хогийн цэгээс ялгарах метан хийн ялгарал 2010 – 2014 онуудад хурдтай өссөн бөгөөд энэ нь УБ хотын хогийн цэг дээр хогийг хөрсөөр хучин дарж булах үйл ажиллагаа сайжирсантай холбоотой юм. Харин үйлдвэрийн уснаас ялгарах метан хийний хэмжээ жил бүр харилцан адилгүй байгаа нь улс орны эдийн засгийн нөхцөл, байдалтай тодорхой байдлаар холбоотой гэдгийг харуулж байна.

Цаашид Монгол Улсын эдийн засаг жил тутам 5-7% өсөх таамаглал байгаа бөгөөд үүнтэй уялдан хотжилт эрчимтэй явагдаж, хүн амын орлого нэмэгдэж, мөн хүн амын өдөр тутмын хэрэглээнд өөрчлөлт орсноор хог хаягдлын хэмжээ тогтвортой өсч, хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хий ч нэмэгдэх хандлагатай байна.

ГУРАВ. САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОЛОН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Монгол Улсын хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулахад чиглэсэн зорилт, үйл ажиллагаа

Хог хаягдлын тухай хууль

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль

Алсын хараа-2050

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого

Ногоон хөгжлийн бодлого

Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030)

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр

Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Ус үндэсний хөтөлбөр

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

ДӨРӨВ. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ,

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

4.1 Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлнэ.

4.1.1 Аймгийн хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

4.1.2 Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, дадал суулгах сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх

4.1.3 Хог хаягдлыг дахин боловсруулах эко үйлдвэрүүдийг байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулна

4.1.4 Шаргалжуут тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэгийг бий болгох

4.1.5 Баянхонгор сумын хуучин хогийн цэгийг орчин үеийн дэвшилтэт технологийн дагуу цэгцэлнэ.

4.1.6 Аймгийн төв болон сумдын оршуулгын газруудыг цэгцлэх, орчин үеийн шарил чандарлах технологийг нэвтрүүлэх

“Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн холбогдох заалтууд:

Зүйл 5.2.10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, хог хаягдлын дахин боловсруулалтын үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.

Зүйл 5.3.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж ажиллана.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

5.1 Өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд

Баянхонгор аймгийн төр засаг, албан байгууллага, иргэдээс байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд сүүлийн жилүүдэд хог хаягдлын асуудалд анхаарлаа хандуулж, энэ чиглэлийн ажлуудыг хийж хэвшин тодорхой үр дүнд хүрч байна. Үүнээс тоймлон дурдвал:

-“Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн зорилт-2028” баримт бичгийг 2018 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор “Цэвэр хот” орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар байгуулагдаж Баянхонгор сумын Засаг даргын 2019 онд дэвшүүлсэн үндсэн зорилт болон менежментийн ерөнхий төлөвлөгөөг удирдлага болгон нийт нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлыг нэгдсэн цэгт төвлөрүүлэх, аж ахуйн нэгж, иргэдийн хог хаягдлыг стандартын дагуу тээвэрлэх, цэвэр орчинг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагаа нь тогтворжин ажиллаж байна.

-Баянхонгор сумын хэмжээнд 2016 онд “Өөрчлөлтийг өрхөөсөө” нэг сарын аян, 2017 онд “Хотоо цэвэр байлгая, Хогоо хаяхаа больё” уриалга хэрэгжүүлэх ажлууд, 2020-2021 онд “Хот соёлтой болгоё” хог ангилан ялгах, шинэ тавьсан хогийн савыг сурталчлах зурагт хуудсыг хийж өрх бүрд тараасан бөгөөд 2021 онд БОАЖГазраас 28.000.000 сая төгрөгний өртөг бүхий 11 ширхэг ангилан ялгах савыг шинээр байршуулсан зэрэг багагүй ажлыг өрнүүлсэн.

-“Эко Баянхонгор” төсөл нь “Тогтвортой хөгжлийн боловсролыг бүх нийтээр эзэмшье” уриалгийн хүрээнд аймгийн БОАЖГазар, Баянхонгор сумын ЗДТГ, Хот тохижилт ОНӨҮГ, Нэгдсэн эмнэлэг, МХГазар, Боловсролын газар, Насан туршийн боловсролын төв болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран “Тогтвортой хөгжил ба Хог хаягдлын менежмент” сургалтыг нийт 17 удаа зохион байгуулж, нийт 460 төрийн албан хаагч, багш, цагдаа, сурагч, хувийн бизнес эрхлэгч нарыг хамруулаад байна.

-2021 оны 2 дугаар сараас аймгийн Нэгдсэн эмнэлэгт ковидын өвчлөлтэй холбоотойгоор шатаах зуухтай болсон бөгөөд эмнэлгийн хог хаягдлыг одоогийн байдлаар бензин асгаж үлдэгдэлгүй шатааж байна.

-“Ашигт хуванцар”, “Хонгор дуулим”, хоёрдогч түүхий эдийн төв зэрэг санаачилгууд болон зарим аж ахуйн нэгж, хувь хүмүүс дахин боловсруулах, ашиглах боломжтой хаягдлыг цуглуулан цаашид оновчтой ашиглах үйл ажиллагааны эхлэлүүд тавигдсан болно.

Дээр дурдсанчлан төрийн ба хувийн байгууллага, ТББ, иргэдийн санаачлага нэмэгдэж байгаа хэдий ч хог хаягдлын нэгдсэн менежментийн тогтолцоо төлөвшөөгүй зарим иргэдийн ухамсар, хандлагаас хамааран хатуу хог хаягдлыг ил задгай хамаагүй хаядаг, тогтмол хугацаанд татан зайлуулдаггүй, хог хаягдлын цэгүүд эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа зэргээс хүрээлэн байгаа орчин бохирдож, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх байдалтай байна.

Иймд ногоон хөгжлийн үзэл санааг дэлгэрүүлэн Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулж, улмаар нөөц, түүхий эдийн хэмнэлттэй, үр ашигтай, хаягдал багатай цэвэр технологийг нэвтрүүлэх замаар хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, бохирдуулагч нь төлбөр төлөх, 3R (бууруулах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах) зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсрыг дээшлүүлэх, хог хаягдлыг зайлуулах дэд бүтцийг бий болгох, чадавхийг бэхжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, бүх нийтийн оролцоотойгоор хамтдаа хог хаягдлыг бууруулж, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэх чиглэлээр зорилго, үйл ажиллагааг тодорхойлж нэн даруй хэрэгжүүлэхэд энэхүү дэд хөтөлбөр ач холбогдолтой юм.

Хог хаягдлын менежментийн тулгамдсан асуудлууд:

2020 оны байдлаар жилийн эцсийн байдлаар Баянхонгор аймгийн нийт 25570 өрх 89329 хүн ам амьдарч 1323 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна. Сүүлийн жилүүдэд хүн амын нягтрал, зам талбай, барилгажилт тэлж Баянхонгор хот болон хөдөө орон нутгаас гарах хог хаягдлын хэмжээ эрс ихэссэн зэрэг нь цаашид тус аймагт хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр бодлогын цогц арга хэмжээ авах шаардлага үүсээд буйг харуулж байна.

“Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн зорилт-2028” баримт бичигт “..хог хаягдал дахин боловсруулах үйлдвэргүй” байгаа нь тулгамдсан асуудлуудын нэг болохыг тодорхойлсон.

Аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 21 энгийн хатуу хог хаягдлын төвлөрсөн хогийн цэг, 82.5 га талбайг эзэлж байна. Хогийн цэг дээр хаягдаж байгаа хог хаягдлыг хэмжээг төрөл бүрээр нь ангилж үзвэл: цаас цаасан бүтээгдэхүүний хаягдал 6658 тонн, шил шилэн бүтээгдэхүүний хаягдал 4711 тонн, хаягдал төмөр 2394 тонн, хуванцар 5511 тонн, барилгын хог хаягдал 8319 тонн, хүнсний бүтээгдэхүүний хаягдал 9938 тонн, цахилгаан барааны хог хаягдал 2201 тонн, авто машины эд анги 1770 тонн, бусад хог хаягдал 18362 тонн хог хаягдал гарч байна.

-Баянхонгор сумын хэмжээнд 2020 онд нийт 598 68,24 тонн энгийн хатуу хог хаягдлыг 2020 онд тээвэрлэн зайлуулсан ба хог хаягдлын хэмжээ цаашид улам нэмэгдэх хандлагатай байгаа тул тус аймагт хог хаягдлын менежментийн шинэ тогтолцоонд шилжих шаардлагатай байгааг харуулж байна.

-Баянхонгор хотын төвлөрсөн хогийн цэг нь хотоос 9 километр орчим зайд Баян-Овоо сумын Уранхайрхан 2 дугаар багийн нутагт байдаг ба тус хогийн цэг нь шинэ суурьшлын бүсийн дээр, үерийн аманд, салхины дээр байрладаг нь хүрээлэн буй орчны бохирдол, хорт утаа, гал түймрийн эрсдэл үүсгэж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд сөргөөр нөлөөлж байна.

-Жил бүр Баянхонгор хот болон хөдөө орон нутгийн нийтийн эдэлбэр газар болон ногоон бүсийн зөвшөөрөгдөөгүй цэгт иргэн аж ахуйн нэгж байгууллага дур зоргоороо хог хаягдал хаяж хүрээлэн буй орчин, хөрсний бохирдлыг ихээр үүсгэж байна.

-Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийн талаар иргэд, малчдын олгох сургалт, сурталчилгааг хийж байгаа хэдий ч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

-Хог хаягдлын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж хог хаягдлын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын хүчин чадал хүрэлцэхгүй хэмжээнд хүрсэн болно.

5.2 Хөтөлбөрийн шаардлага, үндэслэл

Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах нь аймгийн хөгжлийн бодлогын нэн чухал асуудал болж байна. Хүн амын өсөлт, хот сууринд шилжин амьдрах нь нэмэгдэж, аймгийн үйлдвэрлэл үйлчилгээ хөгжиж, хүн амын орлого, хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хог хаягдлын хэмжээ жил бүр нэмэгдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан ба Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Ногоон хөгжлийн бодлого, Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд хог хаягдлын менежментийг сайжруулж хог хаягдлыг бууруулах, хүн амын амьдрах тав тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр зорилтуудыг тодорхойлсон байдаг. 2017 онд шинэчилэн найруулсан “Хог хаягдлын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-д Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрхэд хамааруулан “Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих;” гэж тусгасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

Мөн Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 баримт бичигт заасан “Хүлэмжийн хийг багасган, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхид нийцсэн дэд бүтэц, хүн амын суурьшлыг төлөвлөж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн 6-р зорилтыг хэрэгжүүлэх үндэс болно.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

6.1.1 Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон төр, засгийн бодлогын хэрэгжилтийг хангах;

6.1.2 Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглалтыг хөхүүлэн дэмжих;

6.1.3 Хог хаягдлыг байгаль орчинд хал багатай арга технологиор зайлуулах;

6.1.4 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулах;

6.1.5 Үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг тухайн үүсгэгчээр нь хариуцуулах, бохирдуулагч нь төлбөр төлөх;

6.1.6 Иргэд, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, түншлэлд тулгуурлах;

6.1.7 Олон улсын болон Монгол улсын хог хаягдлын менежментийн тэргүүн туршлагыг өөрийн онцлогт тохируулан бүтээлчээр нэвтрүүлэх.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХУГАЦАА

7.1 Энэхүү хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа нь 2021-ээс 2025 он болно.

НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНДСЭН ЗОРИЛГО

Алсын хараа: Энгийн хог хаягдлын менежмент ба хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад 2025 он гэхэд үндэсний хэмжээнд тэргүүлэгч аймаг болно.

Эрхэм зорилго: “Баянхонгор аймгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах, ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах хог хаягдлын менежментийн тогтолцоог бий болгох” нь энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго юм.

Үндсэн зорилго: Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хог хаягдлын хэмжээг эх үүсвэр дээр нь бууруулж, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулж ашиглахтай холбоотой олон нийтэд ногоон хэрэглээний талаар боловсрол олгож, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэн, хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, менежментийн тогтолцоог сайжруулж, дэд бүтэц санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, цэвэр эрүүл орчин бүрдүүлэх замаар ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжихэд энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго оршино.

ЕС. БОДЛОГЫН ЗОРИЛТУУД

9.1 Эрх зүйн орчин: Хог хаягдлыг бууруулах, ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчинг боловсронгуй болгох

9.1.1 Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасныг үндэслэн эрх зүйн дараах баримт бичгүүдийг боловсруулан батлуулж мөрдөж ажиллах. Үүнд:

9.1.1.1 энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх;

9.1.1.2 энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах;

9.1.1.3 энэ хуулийн 40.4-т заасан урамшуулал олгох журмыг батлах.

9.1.2 Аймгийн хэмжээнд хог хаягдлын төрөл, бүтцийн судалгааг хийх арга аргачлалыг боловсруулж батлуулах.

9.1.3 Хог хаягдлын тухай хууль, төрөөс баримтлах бодлого, аймгийн дэд хөтөлбөр болон мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт, мэдээллийн тогтолцоог аймаг, сумын ИТХ-д бий болгох.

9.1.4 Орчны бохирдлыг эх үүсвэр дээр нь бууруулах зорилгоор хөгжлийн болон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг хог хаягдлын менежмент, байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний дүгнэлтийг үндэслэн хэлэлцэж баталж байх зохицуулалтыг бий болгож хэрэгжүүлэх.

9.1.5 Аймгийн хэмжээнд энгийн болон аюултай хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг үүсгэгчийн бүртгэлд бүртгүүлж, байгаль орчны статистик мэдээллийн сан бүрдүүлэх.

9.1.6 Нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах чиглэлээр арга аргачлал боловсруулж мөрдөх.

9.1.7 Хог хаягдлыг зориулалтын бус газар, тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт хаясан тохиолдолд хог хаягдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх.

9.2 Технологи, үйлдвэрлэл: Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд оновчтой технологийг нэвтрүүлж, хүлэмжийн хийг бууруулах

9.2.1 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, тогтолцоог нэвтрүүлэх.

9.2.2 Аймгийн төвийн хогийн төвлөрсөн цэгийг Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу 1-2 дугаар зэрэглэлийн шаардлага хангах ландфилл цэгийг шинээр байгуулах.

9.2.3 Сумдуудын хогийн төвлөрсөн цэгүүдийг хог хаягдлын хуульд заасны дагуу 3-дугаар зэрэглэлд үе шаттайгаар шилжүүлэх.

9.2.4 Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор дахивар, түүхий эд цуглуулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах санал санаачилга төслүүдийг дэмжиж, энэ чиглэлээр жижиг үйлдвэрлэлийг бүсчилсэн байдлаар бий болгож хөгжүүлэх.

9.2.5 Органик хог хаягдал, тэр дундаа хүнсний, биомассын хог хаягдал, малын өтөг бууцыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх тогтолцоог бүрдүүлж, дахин боловсруулах, бордоо болгох, түлш, эрчим хүч гаргах технологи бүхий үйлдвэрийг байгуулах ТЭЗҮ боловсруулах.

9.2.6 Аймгийн төв болон сумдын оршуулгын газруудыг цэгцлэх, хөрсний бохирдлыг бууруулах, ногоон цэцэрлэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

9.2.7 Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний тогтолцоог ажиллах хүч, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний хуваарийг шинэчлэн энэ чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог дэмжих.

9.2.8 Аймгийн нутаг дэвсгэрт аливаа хог хаягдал нэн ялангуяа аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд мэдээллийн технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх.

9.2.9 Аймгийн хэмжээнд бүх салбарт саарал усны технологийг нэвтрүүлэх.

9.3 Санхүү, менежментийн тогтолцоо: Хог хаягдлыг багасгах, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн менежментийн тогтолцоог бүрдүүлж, хөрөнгө оруулалтыг татах

9.3.1 Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулж, холбогдох санал санаачилга төслүүдийн туршилтын ба үйл ажиллагааг эхлүүлэхэд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх.

9.3.2 Аймгийн төр, хувийн хэвшлийн байгууллагууд байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001 стандартыг нэвтрүүлэх ажлыг дэмжиж, хөнгөлөлттэй зээл олгох, гэрчилгээ авч баталгаажсан байгууллагыг сурталчлах ажлыг зохион байгуулах.

9.3.3 Хог пресслэх болон хог тээвэрлэх зориулалт бүхий техник, автомашинаар хангах хүчин чадлыг нэмэгдүүлэх.

9.3.4 Хог цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, устгах, булшлах ажиллагаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн оролцоог бодлогоор дэмжих, үйлчилгээний үнэ тарифыг зөвшилцөн тогтоох.

9.3.5 Уул уурхай, барилга, авто тээврийн хэрэгслийн болон бусад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх менежментийг нэвтрүүлэх.

9.3.6 Аймаг, сумдын худалдааны төв, томоохон үйлчилгээний төвүүд, авто засварын төв, машин угаалгын газруудын энгийн болон аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах боломжтой эрх бүхий байгууллагуудад шилжүүлэх ажлыг бодлогын хувьд дэмжиж ажиллах.

9.3.7 Аймгийн хэмжээний эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг устгах байгууламжийг байгуулах чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагуудын санал санаачлагыг дэмжиж ажиллах.

9.4 Мэдлэг, мэдээлэл: Хатуу, шингэн хог хаягдлаас ялгарч буй хүлэмжийн хий, түүний уур амьсгалын өөрчлөлт, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх

9.4.1 Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар аймгийн иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, дадал суулгах сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх.

9.4.2 Хог хаягдлын талаарх цогц ойлголт олгох сургалтыг сургуулийн өмнөх насны болон ерөнхий боловсролын сургалт-хүмүүжлийн ажлын хөтөлбөрт оруулж, зөв дадлыг төлөвшүүлэх.

9.4.3 Төрийн ба хувийн хэвшлийн удирдах ажилтнууд болон холбогдох мэргэжилтнүүдэд “Ногоон хөгжил, хог хаягдлыг бууруулах” чиглэлээр сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж чадавхийг бэхжүүлэх.

9.4.4 Хатуу, шингэн хог хаягдлаас ялгарч буй хүлэмжийн хий, түүний уур амьсгалын өөрчлөлтөнд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээ, мэдээлэл хүргэх сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө боловсруулж, үе шаттай зохион байгуулах

9.4.5 Аймгийн хэмжээнд хоггүй шилдэг сум, баг болон аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах кампанит ажлыг жил бүр тогтмол зохион байгуулах.

9.4.6 Баянхонгор аймгийн Боловсролын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Насан туршийн боловсрол, Политехникийн коллеж, аймгийн хэмжээний бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг түшиглэн “Эко Баянхонгор” төслийн хүрээнд “хог хаягдлын сургагч багш” бэлтгэж, сум, баг, хэсгийн ахлагч нарт иргэдтэй хамтран ажиллах чадавхийг бэхжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах.

9.4.7 Иргэд, олон нийтэд хог хаягдлын боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлын явц, тэргүүн туршлага болон судалгаа, мониторингийн ажлын талаар аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, интернет хуудас, бүлгүүдтэй нягт хамтран ажиллах.

9.4.8 Хог хаягдлын талаар нийтийн боловсрол олгох, ангилан ялгах, дахин ашиглах чиглэлээр олон улсын болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

10.1 Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

10.1.1 улсын болон орон нутгийн төсөв;

10.1.2 хог хаягдлын үйлчилгээний хураамж;

10.1.3 олон улсын байгууллага, хандивлагчийн зээл, тусламж;

10.1.4 аж ахуйн нэгж, байгууллагаас гаргах хөрөнгө;

10.1.5 бусад эх үүсвэр

10.2 Хөтөлбөрийн зардлын дүн (2021-2025)

Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд 2021-2025 онд нийт 25.1 их наяд төгрөг шаардагдах болно. Үүнд:

10.2.1 улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 19.4 их наяд төгрөг

10.2.2 зээл, тусламжийн санхүүжилт 421 сая төгрөг

10.2.3 бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх 5.3 их наяд төгрөг

10.3 Үүнээс сумдад хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардлын дүн: 8.2 их наяд төгрөг

АРВАН НЭГ. ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕХАНИЗМ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

11.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэрэгслийг ашиглана.

11.1.1 эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

11.1.2 эдийн засгийн хөшүүргийг хэрэглэх;

11.1.3 нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

11.1.4 мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;

11.1.5 төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

11.1.6 санхүүжилтийн шинэ эх үүсвэр бий болгох;

11.1.7 шинэ техник, технологи нэвтрүүлэх.

11.2 Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрүүдэд үндэслэн энэ баримт бичгийн хүрээнд боловсруулсан мастер төлөвлөгөө, төслүүдэд тусган хэрэгжүүлнэ. Аймгийн хөтөлбөрт тулгуурлан сум бүр хог хаягдлыг бууруулах мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Японы Ойта муж, БНБУ-ын Русе, БНСУ-ын Ансан, БНХАУ-ын Нинша Хуй болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алша аймаг, Ганьсу муж зэрэг гадаад түншүүдтэй тогтоосон хамтын ажиллагаагаа өргөн ашиглана.

11.3 Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ гол сонирхогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэн, үүрэг оролцоо, манлайллыг идэвхжүүлэх арга, замыг тулгуурлана. Үүнд:

11.3.1 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа,

11.3.2 Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл явцад (үйлдвэрлэх, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, боловсруулах, зайлуулах) урамшуулал, дэмжлэг үзүүлэх

11.3.3 Хог хаягдал үүсгэгчийн үүрэг хариуцлага, олон нийтэд сурталчлах кампанит ажил, боловсролыг нэвтрүүлэх,

11.3.4 Хог хаягдлын менежментийн мөчлөгт үр ашиг, нэмүү өртөг бий болгох,

11.3.5 Хог хаягдлын менежментийн тэргүүн туршлага, төрийн ба хувийн хэвшлийн байгууллага, ОНБ, иргэдийн санаачилгыг сайшаан сурталчлах

11.3.6 Улаанбаатарт байгаа албан ёсны дахин боловсруулах үйлдвэрүүдтэй холбоо тогтоохын тулд хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг болно.

11.4 Тайлагнал, үр дүнг дүгнэх: Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн жил бүрийн хэрэгжилтийг аймгийн Засаг дарга дараа жилийн эхний хагаст багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

11.5 Энэхүү дэд хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад зорилтуудын хүрээнд тусгагдсан хүрэх түвшингийн үзүүлэлтүүдийг ашиглан хяналт, шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

11.5.1 Дэд хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэн дүгнэх үе шатууд:

11.5.1.1 I үе шат: Бодлогын зорилтын эхний шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2022 оны 6 дугаар сар);

11.5.1.2 II үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2023 оны 6 дугаар сар);

11.5.1.3 III үе шат: Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2025 оны 6 дугаар сар)

11.6 Хяналт, шинжилгээ, үнэлгээг аймгийн төрийн захиргааны байгууллага холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хийх бөгөөд зохих зардлыг төсөвт тусган санхүүжүүлнэ.

АРВАН ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ХҮРЭХ ҮР ДҮН

12.1 Хөтөлбөр хэрэгжсэнээр хог хаягдлын зохистой менежментийн эхлэл тавигдаж, иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын хог хаягдлын талаарх боловсрол, хариуцлага дээшилж, нийт хог хаягдлын 20-оос доошгүй хувийг эргүүлэн ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дахин боловсруулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшиж, хог хаягдлын урсгалын статистик мэдээ, цахим сан бүрдүүлэх, аюултай хог хаягдал хуримтлагдахаас сэргийлэх чадавх бүрдсэн байна.

12.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2020 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ.

Шалгуур үзүүлэлт	нэгж	Суурь үзүүлэлт		Хүрэх түвшин	
		2022 он	2023 он	2025 он	2030 он
АЛСЫН ХАРАА-2050 дагуу:					
Хог дахин боловсруулалтын хэмжээ	хувь	0,4	10	20	30
Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын хэмжээ	хувь	35	40	50	64
Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001 стандарт нэвтрүүлсэн, эко тэмдэг, ногоон гэрчилгээ авсан этгээдийн тоо	тоо	3	5	6	30
БУСАД ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	мян.тн	62.3	62.7	63.1	
	хувь	95.6	90	78	
Эх үүсвэр дээр ангилан ялгах хог хаягдлын	хувь	0	20	50	
Нийт хог хаягдалд дахин боловсруулсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн хаягдлын эзлэх хувь	хувь	4.4	10	22	

Нийт үүсч буй органик хог хаягдлын хэмжээнд дахин боловсруулж буй органик хог хаягдлын хувь эзлэх хувь		0	15	30
Хог хаягдлыг бууруулах менежментийн тоо	тоо	5	7	8
1,2-р зэрэглэлийн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн тоо:			5	
(Аймгийн төв-1р зэрэглэл, 19 сумдад 3-р зэрэглэл)	тоо	0	(Үүнээс аймгийн төвд 1)	15